

БАТЛАВ. ЗАСАГ ДАРГА

Г.АНХБАЯР

**ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ ХЯНАЛТ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ТУХАЙ УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл:

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 дүгээр сарын 23-ны өдрийн 81 дугаар тогтоол, ХХААХҮСайдын 2021 оны 12 дугаар сарын 13 ны өдрийн А/361 дугаар тушаал “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын” 1.1, 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3, 4.9, 7 дугаар зүйлийн 7.1, 7.4 заасныг тус тус үндэслэн болгон Хоршоог хөгжүүлэх санд /цаашид “Сан” гэх/ хяналт, шалгалт зохион байгуулах.

Хоёр. Зорилго:

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилт, үр дүнгийн байдалд үзлэг зохион байгуулан санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулан цаашид авах арга хэмжээг тодорхойлоход чиглэгдсэн байна.

Гурав. Хамрах хүрээ, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Сумын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1. Сангийн зээл, зээлийн үлдэгдэлтэй 2011-2022 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалт, төлөвлөлтийн байдал;
2. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаас сангийн чиглэлээр явуулсан үйл ажиллагаа;
3. Сумын хоршоог хөгжүүлэх сангийн бодлого чиглэлийг тодорхойлсон байдал;
4. Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн үйл ажиллагаа;
5. Сангаас олгосон зээлийн болон санхүүгийн анхан шатны баримт материалын бүрдүүлэлт;
6. Сангийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан;
7. Зээлийн мэдээллийн санд холбогдох мэдээллийг бүртгэх, түүнтэй холбоотой мэдээллийг зээлдэгчдэд хүргэх.
8. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлдэгчдэд холбогдох арга хэмжээ авч, Зээлийн мэдээллийн санд бүртгэхтэй холбоотой мэдэгдэл хүргүүлэх.
9. Хойшид сангийн үйл ажиллагааг сайжруулах талаарх санал дүгнэлт.
10. Бусад үйл ажиллагаа.

Дөрөв: Ажиллах хугацаа

2022 оны 7 дугаар сарын 27-ны өдрөөс 7 дугаар сарын 28-ны өдөр хүртэл ажиллана.

Тав.: Ажлын хэсгийн ажил үүргийн хуваарь

1. Сумын Засаг дарга, асуудал хариуцсан мэргэжилтэн нар үзлэг зохион байгуулахтай холбоотойгоор бэлтгэл ажлыг хангаж дараах үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.

- Сангийн 2011-2022 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалт, төлөвлөлт;
- Сангийн бодлого чиглэлийг тодорхойлсон байдал;
- Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн үйл ажиллагаа;
- Хяналт тавих зөвлөлийн үйл ажиллагаа;
- Сангаас олгосон зээлийн болон санхүүгийн анхан шатны баримт материалын бүрдүүлэлт;
- Сангийн санхүүгийн үйл ажиллагааны тайланг бэлтгэх;
- Сум хөгжүүлэх сангийн бүртгэл, хяналт, нэгтгэлийн Зээлийн мэдээллийн санд холбогдох мэдээллийг бүртгэж, үүнтэй холбоотой мэдээллийг зээлдэгч бүрт хүргэн гарын үсэг зуруулж баталгаажуулах; /мэдэгдэл хүргэх маягтын дагуу/
- Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлдэгчдэд Зээлийн мэдээллийн санд бүртгэх тухай мэдэгдэл хүргэн гарын үсэг зуруулж баталгаажуулах.
- Зээлээ хэрхэн төлж барагдуулах талаар зээлдэгчтэй хийсэн гэрээ, нотлох баримт.
- Ажлын хэсгийн гишүүдийн суманд ажиллах ажлын урьдчилсан бэлтгэлийг хангаж, сумдын Засаг дарга нарт чиглэл, зөвлөмж өгөх;
- Үзлэг зохион байгуулсан тухай тайланг зээлийн эргэн төлөлтийг сайжруулах талаарх саналын хамт аймгийн засаг дарга, ХХААГ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэр хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын нэр дээр гарын үсэг зурж баталгаажуулан хүргүүлэх;

2.Хяналтын зөвлөл зохион байгуулагдсан ажлын хэсэг дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Сангийн 2011-2022 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалт, төлөвлөлтийг шалгах;
 - Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаас сангийн чиглэлээр явуулсан үйл ажиллагааг шалгах;
 - Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас сангийн үйл ажиллагаанд хяналт тавих, төсөл сонгон шалгаруулах болон, хяналт тавих орон тооны бус зөвлөлийг томилсон байдалд хяналт тавих, авсан арга хэмжээ шалгах;
 - Сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон байдал;
 - Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн үйл ажиллагааг шалгах;
 - Хяналт тавих зөвлөлийн үйл ажиллагааг шалгах;
 - Сангаас олгосон зээлийн болон санхүүгийн анхан шатны баримт материал бүрдүүлэлтийг шалгах;
 - Сангийн санхүүгийн үйл ажиллагааг шалгах;
 - Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлдэгчдэд холбогдох арга хэмжээ авч, Зээлийн мэдээллийн санд бүртгэхтэй холбоотой мэдэгдэл хүргэсэн байдлыг шалгаж, холбогдох үүрэг даалгаврыг газар дээр нь өгч шийдвэрлүүлэх;
1. Авилгатай тэмцэх газраас 2022 оны 07 дугаар сарын 01 ны өдрийн албан тоот зөвлөлж хүргүүлсэн хүснэгтийг үнэн, зөв бөглөн, зээлийн эргэн төлөлтийг хэрхэн сайжруулах талаар санлын хамт боловсруулж зөвлөмжийн хэрэгжилтийг гарган баталгаажуулж 2022 оны 8 дугаар сарын 10 ны дотор ХХААГ-т хүргүүлэх.
- Зээлийн мэдээллийн санд холбогдох мэдээллийг бүртгэх, түүнтэй холбоотой мэдээллийг зээлдэгчдэд хүргэх зэрэг асуудлыг нэгтгэн цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргаж танилцуулах.

Зургаа: Ажлын хэсгийн зардал

Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаа болон бусад зардлыг журмын 2 дугаар зүйлийн 2.7 дахь заалтын дагуу олгоно.

Долоо: Хориглох зүйл

Ажлын удирдамжид зааснаас бусад үйл ажиллагаанд оролцох, хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Найм: Үр дүнг тайлагнах

1. Ажлын хэсэг ажилласнаас хойш хуанлийн 5 хоногийн дотор ажлын тайланг нэгтгэн гарын үсэг зурж баталгаажуулан Сумын ИТХуралд хүргүүлэх.
2. Ажлын хэсэг ажлын 5 хоногт багтаан санал дүгнэлт гаргаж цаашид авах арга хэмжээ, төлөвлөгөө, санал, зөвлөмжийн талаар Аймгийн ИТХурал, ХХААГазар, Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлэн тайлагнана.

Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнг дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Зохистой харьцаа /жилээр/
1	Зээлийн эргэн төлөлт	Нийт хөрөнгийн 30-аас доошгүй хувийг бүрдүүлсэн байх
2	Чанаргүй зээлийн хэмжээ	Нийт хөрөнгийн 10 хувиас бага байх
3	Хяналт тавих үйл ажиллагаа	Жилд 2-оос доошгүй удаа
4	Олон нийтэд тайлагнасан байх	Жилд 1-ээс дээш
5	Тайлан, мэдээ	Улирал бүр
6	Ажлын байр нэмэгдүүлсэн байх	10-аас дээш хувь тогтоох

ЕС: Санамж

7.2.Сангийн үйл ажиллагаа нийтэд ил тод, нээлттэй байна. Сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналтын зөвлөл хяналт тавих бөгөөд шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэж болно.

7.3.Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгах бөгөөд хөнгөлөлттэй зээлийг зориулалтын бусаар зарцуулсан, зээлийн гэрээнд заасан заалтыг зөрчсөн зээлдэгчийн зээлийн гэрээг цуцалж, зээлийг Сангийн дансанд буцаан төвлөрүүлэх ажиллагааг зохион байгуулна.

7.4.Хяналтын зөвлөл сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавихдаа дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ

7.4.1.зээл авсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн тайлан, дансны мэдээллийг гаргуулан авах;

7.4.2.сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад хүргүүлнэ

7.4.3.аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллагын хамт жилд нэгээс доошгүй удаа сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүнг аймагийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлэх.

7.5.Сумын Засаг дарга сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг улирал болон жилээр гаргаж, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор тухайн аймгийн Засаг даргад хүргүүлнэ.

7.6.Аймгийн Засаг дарга энэ журмын 7.5-т заасан сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн улирлын болон жилийн тайланг нэгтгэн, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

7.7.Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 7.6-д заасан тайланг нэгтгэн, мөн журмын 7.9-д заасан аудитын дүгнэлтийн хамт тухайн жилийн I улиралд багтаан Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.8.Аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага сангийн үйл ажиллагаа, орлого, зарлагын гүйцэтгэлд жил бүр хөндлөнгийн аудит хийлгэж, аудитын дүгнэлтийг тухайн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлнэ.

7.9. Аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага энэ журмын 7.8-д заасан аудитын дүгнэлтийг аймгийн хэмжээнд нэгтгэн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн жилийн 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

7.10.Сангийн зээлдэгч нь төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлж, зээл, зээлийн хүүгийн төлбөрийг гэрээний үүргийн дагуу төлж, төслийн талаархи тайланг жилд нэг удаа сумын иргэд, олон нийтэд тайлагнана.

7.11.Хоршоо нь сумын иргэдийн хоршиж хөдөлмөрлөх идэвх санаачлагыг дэмжих, шинээр ажлын байр бий болгох, ажлын байрыг тогтвортой хадгалах, эрүүл, аюулгүй хүнс, үйлчилгээгээр хангах, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэх, орон нутгийн нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах үүрэг хүлээнэ.